

ЭРДЭНЭ РЕСУРС НЬ ХӨВИЙН ХАР МОЛИБДЕН - ЗЭСИЙН ТӨСЛИЙН СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот
2021.07.15

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт, Хөндий Алтны Дүүргээс 30 км зүүн зүгт байрлах өөрийн 100 хувь эзэмшлийн Хөвийн Хар молибден-зэсийн төслийн ("Төсөл") стратегийн үнэлгээг эхлүүлээ. Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбай нь ашиглалтын шатанд шилжээгүй байгаа Ази дахь хамгийн том молибден-зэсийн нөөцүүдийн нэг болох Зуун Мод ордыг агуулдаг бөгөөд зэс, молибденийн олон хэтийн төлөв бүхий талбайг агуулдаг.

Төслийн онцлох мэдээлэл

- Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшдэг Хөвийн Хар тусгай зөвшөөрөл нь 6041 га талбайг хамардаг бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 60 жилийн хугацаатай.
- Тусгай зөвшөөрлийн талбай нь Азийн хэмжээнд ашиглаж эхлээгүй томоохон молибден-зэсийн ордуудын нэг болох Зуун Мод ордыг агуулсан томоохон порфирийн системээс гадна хэд хэдэн зэсийн хэтийн төлөв бүхий талбайг агуулдаг.
- Зуун Мод нь NI 43-101 тайлангаар 273.5 сая фунт (124 мянган тонн) молибден, 330.7 сая фунт (150 мянган тонн) зэс бүхий баттай болон бодитой нөөц, 157.7 сая фунт (71.4 мянган тонн) молибден, 197.7 сая фунт (89.6 мянган тонн) зэсийн боломжтой нөөц агуулдаг.
- Зуун Модоос баруун хойд зүгт 2.2 км-т 1.3% зэс болон 9.2 г/т мөнгөний агуулга бүхий 34 метрийн интервал огтолсон бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайн дийлэнх хэсэгт хайгуулын ажил бүрэн хийгдээгүй.
- Төслийн талбай нь дэлхийн хамгийн том зэс-молибденийн хэрэглэгч, ган үйлдвэрлэгч улс болох БНХАУ-ын хилийн боомтоос баруун хойд зүгт 180 км-т байрладаг.

Тодруулга

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Зэс молибденийн эрэлт сүүлийн үед нэмэгдэж, урт хугацааны зах зээлийн ханш эерэг төлөвтэй байгаа нь Хөвийн Хар төслийн стратегийн үнэлгээг эхлүүлэх хүчин зүйл боллоо. Нөөцийг тэлэх боломж бүхий Ази тив дэх хамгийн том ашиглаж эхлээгүй молибден-зэсийн төслүүдийн нэг тул Компани нь энэхүү төслийн үнэ цэнийг хувьцаа эзэмшигчдэд хүртээх боломжуудыг эрэлхийлж байна. Энэхүү стратегийн үнэлгээний

хүрээнд Компани нь төслийн үнэлгээг тодорхойлох, үүнд: худалдах, хамтарсан түншлэл байгуулах, салгах зэрэг нөхцлүүдийг үнэлнэ.”

Хөвийн Хар Молибдени-зэсийн төслийн тухай

Хөвийн Хар молибден-зэсийн төсөл нь Монгол Улс болон БНХАУ-ын хил, Нарийн Сухайт нүүрсний уурхайн цогцолбороос хойд зүгт ойролцоогоор 180 км зайд, Баянхонгор аймгийн нутагт оршдог. 6,041 га талбайг хамран оршдог Хөвийн Хар ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд олгосон бөгөөд тусгай зөвшөөрөл нь 60 жилийн хугацаанд хүчинтэй. Төслийн талбай нь Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий Алтны Төслөөс зүүн зүгт 30 км-т оршдог.

2002 онд WMC Resource Project Ltd (WMC) ба Gallant Minerals Mongolia Ltd (Gallant) нарын хамтарсан хөрөнгө оруулалттайгаар энэхүү төслийн хайгуулын хөтөлбөр эхэлсэн. Энэхүү хөтөлбөрөөр цогцолборын зүүн өмнөд болон хойд бүсэд хязгаарлагдмал өрөмдлөгийн хөтөлбөрөөр зэс-молибден-рени (Cu-Mo-Re) эрдэсжилттэй томоохон порфирийн цогцолборыг тодорхойлсон. Галлант Минерал-аас 2005 онд энэхүү төслийг эзэмших эрхийг худалдан авснаар Эрдэнэ Ресурс нь 16 км радиус бүхий порфирийн цогцолборын гадна захад Зуун Мод молибден-зэсийн орд, зэс, молибденийн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлох хайгуулын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн.

2011 онд Minarco-MineConsult (өнөөгийн RPMGlobal) нь Зуун Мод ордыг агуулж буй порфирийн системийн 3 км талбайд NI 43-101 нөөцийн тооцооллыг боловсруулсан. Зуун Мод молибден-зэсийн төсөл нь 0.04% молибденийн захын агуулга бүхий тооцооллоор 0.057% молибден ("Mo"), 0.069% зэс ("Cu") агуулга бүхий 218 сая тонн баттай ба бодитой нөөц тооцоологдсон. Энэ нь 273.5 сая фунт (124 мянган тонн) молибден, 330.7 сая фунт (150 мянган тонн) зэсийн металлтай тэнцэж байна. Түүнээс гадна 0.052% молибден, 0.065% зэсийн агуулга бүхий 138 сая боломжтой нөөц тооцоологдсон нь 157.7 сая фунт (71.4 мянган тонн) молибден, 197.7 сая фунт (89.6 мянган тонн) зэсийн металлтай тэнцэж байна.

Хүснэгт 1. Зуун Мод Төслийн эрдсийн нөөцийн тооцоолол, 2011 оны 6 сар

Захын агуулга Mo%	Төрөл	Хэмжээ Mt	Mo %	Mo агуулсан металл Mlbs	Cu %	Cu агуулсан металл Mlbs
0.03%	Баттай	55	0.05 0	61.1	0.06 0	73
	Бодитой	260	0.050	287	0.06 5	373.6
	Баттай & Бодитой	315	0.05 0	348.1	0.06 4	446.6
	Боломжтой	275.4	0.04 3	262.1	0.06 1	373.7
	Баттай	40	0.05 6	49.5	0.06 4	57
	Бодитой	178	0.05 7	224	0.07 0	273.7

0.04%	Баттай & Бодитой	218	0.057	273.5	0.069	330.7
	Боломжтой	138	0.052	157.7	0.065	197.7
	Баттай	25	0.063	34.5	0.068	37.5
	Бодитой	105	0.066	152.5	0.074	171
0.05%	Баттай & Бодитой	130	0.065	187	0.073	208.5
	Боломжтой	64	0.060	85.0	0.067	94.9

Эх сурвалж: NI 43-101 Technical Report, Zuun Mod Porphyry Molybdenum-Copper Project, Minarco-MineConsult, June 2011

Зууд Мод төслөөс гадна Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбай нь хэд хэдэн хэтийн өндөр төлөв бүхий зэс ба молибденийн талбайг агуулдаг. Зуун Мод порфирийн цогцолборын хойд хэсэгт байрлах Хөвийн Хар талбай нь филик ба потасик хувирлын кварц, монзонит ба гранодиоритын интрузив бүхий хэдэн км зайд тархсан зэсийн эрдэсжилт бүхий томоохон талбайг хамардаг. Өргөн зайн өрөмдлөгөөр хэд хэдэн эрдэсжсэн бүсүүдийг огтолсноос дурдвал (ZMD-121) цооногт 308-аас 342 метрт 1.3%цэс, 9.24 г/т мөнгөний агуулга бүхий 34 метрийн интервал огтолсон. Энэхүү бүс нь андезитийн бүрхүүлийн доорх трендийн дагуу оршиж байгаа нь гүндээ болон баруун өмнөд чигт нээлттэй.

Хөвийн Хар молибден-зэсийн төслийн стратегийн үнэлгээ

Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлснээр Эрдэнэ Ресурс нь энэхүү бүс нутаг дахь үнэт металлын ордуудын хайгуул, хөгжүүлэлтэд төвлөрөн ажилласан. Өнөөгийн зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан, Эрдэнэ Ресурс нь дараах шалтгаанаар Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбайн молибден, зэсийн нөөцийг дахин үнэлэх ажлыг эхлүүлэв:

- Зэс ба молибденийн үнэ өнгөрсөн жилүүдэд өссөн ба ойрын хугацаанд тогтвортой чанга байх төлөвтэй байна;
- 2017 оноос хойш БНХАУ-ын дотоодын эрэлт өссөн шалтгаанаар молибденийн импорт 24% хүртэл өсч, мөн хугацаанд дотоодын молибденийн нийлүүлэлт 8%-иар буурсан;
 - Молибденийн цэвэр импортын хэмжээ 2019 оны 1.4 сая фунтаас 2020 онд 100 сая фунт хүртэл нэмэгдсэн.
 - Молибденийг голлон Өмнөд Америк, Армени, Хойд Америкаас импортолж байна.
- Монгол Улсын баруун өмнөд бүс болон БНХАУ-ын баруун хойд бүсийн дэд бүтэц харьцангуй сайжирсан;
 - Монгол Улс болон БНХАУ-ын хилийн ойролцоо өргөтгөсөн сайжруулсан авто зам тавигдсан;
 - Монгол Улсын шинээр төлөвлөж буй төмөр замын төслүүд нь Зуун Мод төслийн ойролцоо маршрутаар баригдахаар төлөвлөгдсөн.

Молибденийн тухай

Дэлхийн молибденийн зах зээл 2020 онд 546 сая фунтээр хэмжигдэж, өнөөгийн зах зээлийн ханшаар 10.2 тэрбум ам.долларын үнэлгээтэй байв. Молибден нь дайвар металлын ангилалд багтдаг бөгөөд хатуулаг, бат бөх чанар, зэврэлтэд тэсвэртэй байдал, цахилгаан дамжуулах чанарыг нэмэгдүүлэх зорилгоор хайлштай ган хэлбэрээр ашиглагддаг уян хатан, зөөлөн чанарын элемент юм. Инженерийн ган, зэвэрдэггүй ган, химийн салбарууд нь молибденийн хэрэгцээний 75%-ийг бүрдүүлдэг.

2020 оны молибденийн үйлдвэрлэлийн 90% гаруйг таван улс (БНХАУ, Чили, АНУ, Перу ба Мексик) бүрдүүлсэн. Хойд ба Өмнөд Америк нь тус бүр 22.9% ба 29.3%-ийг эзэлж байна. БНХАУ нь 2020 онд дэлхийн нийт нийлүүлэлтийн 40%-ийг бүрдүүлж, дэлхийн хамгийн том үйлдвэрлэгч болсон.

БНХАУ нь молибденийн хамгийн том хэрэглэгч улс. БНХАУ-ын молибденийн цэвэр хэрэглээ 2019 оны 1.4 сая фунтээс 2020 оны 100 сая фунт болж өссөн. БНХАУ нь молибденийн үлдсэн хэрэглээг АНУ, Перу болон Армениас импортоор авдаг.

Компанийн тухай

Компанийн тухай Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өндөр агуулга бүхий алт, алт суурь металлын хэтийн төлөв бүхий талбайнуудыг нээн илрүүлснээс хөгжүүлэлт хийх боломжтой хэмээн Баян Хөндий, Алтан Нар ордуудыг тодорхойлсон.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com -оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологч)

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж

байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com


Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>


LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>

Зураг 1: Зуун Мод төслийн байршил ба Евразийн молибденийн эрэлт & нийлүүлэлт



Зураг 2: Эрдэнэ Ресурс – Алт, зэс ба молибденийн ордууд болон хэтийн төлөв бүхий талбай – Эдрэнгийн Террейн зүүн өмнөд хэсэг



Зураг 3: Хөвийн Хар Порфирийн цогцолбор

